



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

**12**  
АНГИ

# НИЙГЭМ СУДЛАЛ

*ХУВИЛБАР А*

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....



### САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн зааврыг сайн уншаарай.
- Сонгох даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР

1. Нийгмийн тодорхой хэрэгцээг хангахын тулд хэм хэмжээтэй, дахин давтагддаг үйлдлээрээ холбогдсон нийгмийн байр суурийн нэгдлийг юу гэж нэрлэдэг вэ?  
A. Нийгэм  
B. Нийгмийн институт  
C. Нийгмийн харилцан үйлчлэл  
D. Нийгмийн бүтэц
2. “Эрэгтэй, эмэгтэй хүний нийгмийн бүтэц, соёлоос хамааран тодорхойлогдох ялгаа” гэсэн тодорхойлолт дараах ойлголтуудын алиныг нь илэрхийлж байна вэ?  
A. Жендэр  
B. Биологийн шинж тэмдэг  
C. Хүйс  
D. Хүйсийн харьцаа
3. Тун бага хувийг эзэлдэг ч баялгийн дийлэнхийг эзэмшдэг бөгөөд байр суурь нь үе залгамжилдаг орчин үеийн нийгмийн давхраажилт аль нь вэ?  
A. Дээдийн дээд анги  
B. Дундын дээд анги  
C. Дээдийн дунд анги  
D. Дээдийн доод анги
4. Төрийн удирдлага нь бюрократ байгууллагын тогтолцоо, зэвсэгт хүчинд суурилсан байдаг бөгөөд гэр бүл, шашны институтийн үүрэг суларсан нийгмийн байгуулал аль нь вэ?  
A. Ан агнуурын нийгэм  
B. Газар тариалангийн нийгэм  
C. Цэцэрлэг аж ахуйн нийгэм  
D. Аж үйлдвэржсэн нийгэм
5. Соёлын шокийг даван туулах үйл явц нь тодорхой үе шатыг дамждаг ба тэдгээр шатыг юу гэж нэрлэдэг вэ?  
A. Соёлд дасан зохицох зам  
B. Соёлын тулгалт  
C. Соёлыг даван туулах зам  
D. Соёлын солилцоо
6. Соёлыг антропологийн хандлагаар хэрхэн тайлбарлах вэ?  
A. Соёлын утга санаа нь хүний гэх зүйлийг амьтны гэх зүйлээс ялгах хязгаар болж өгдөг хэмээн тайлбарладаг.  
B. Янз бүрийн ард түмний домог, аман зохиол зэрэг соёлын уламжлалыг харьцуулан судлах замаар тайлбарладаг.  
C. Соёлыг хүний мөн чанарын илэрхийлэл болох талаас нь тайлбарладаг.  
D. Соёлыг аливаа нийгмийн аж төрөх ёс, нийгмийн зохион байгуулалтыг бүрдүүлэгч хүчин зүйл гэдэг талаас нь тайлбарладаг.
7. “Соёл бүрийн зан үйлийн хэм хэмжээ, дүрмийг адилхан хүндэтгэвэл зохино” гэж үздэг үзэл аль нь вэ?  
A. Соёлын статик  
B. Соёлын этноцентризм  
C. Соёлын динамик  
D. Соёлын релятивизм

8. Дараах өгөгдөлд байгаа эрдэмтдийг үзэл санаатай нь зөв байршуулна уу.

Өгөгдөл: /1-Ж. Локк, 2-Э. Фромм, 3-Ж. Мердок, 4-Дж. Кэмпбелл, 5-Э.Тайлор/

a.....	Хуурмаг эрх чөлөө нь хүнийг ганцаардуулж, хорвоо ертөнцөд итгэх юмгүй айж хугарсан нэгэн болгодог
b.....	Бид хараат байдлаас гарч, эрх чөлөөг оллоо гэхэд юу хийхээ мэддэг байх нь хамгийн чухал бөгөөд эрх чөлөөтэй байх эсэх нь хувь хүнээс өөрөөс нь шалтгаална
c.....	Хуулийн зорилго нь хүний эрхийг устгах буюу хавчин хасах явдал биш, Харин түүнийг хамгаалж өргөжүүлэх явдал мөн

- A. a5,b3,c4                      B. a3,b2,c4                      C. a4,b2,c1                      D. a2,b4,c1

9. Дараах эрдэмтдийн алиных нь онол макро эдийн засгийн онолын цаашдын хөгжил болон барууны орнуудын төрийн эдийн засгийн бодлогод чухал нөлөө үзүүлсэн бэ?

- A. А. Смит                      B. Ф. Хайек                      C. М. Кейнс                      D. Д. Рикорда

10. Чөлөөт эдийн засгийн тогтолцооны хоёрдогч чухал шинж нь аль вэ?

- A. Нийтийн өмч                      C. Ашгийн хойноос хөөцөлдөх  
B. Хувийн өмч                      D. Төрийн оролцоо хязгаарлагдмал

11. Хүн болгоны ашиг хонжоо хайсан үйл ажиллагаа нь эцсийн дүндээ нийгмийн баялгийг бүтээж арвижуулдаг гэж үздэг нь аль урсгал чиглэлийн гол онцлог вэ?

- A. Меркантилизм                      C. Сонгодог эдийн засгийн онол  
B. Шинэ сонгодог онол                      D. Монетаризм

12. Дараах ойлголтуудыг зөв тохируулна уу.

a	Газар, Хөдөлмөр	1	Хүчин зүйл
b	Үйлдвэрлэлд ашиглагдах бүх төрлийн нөөцүүд	2	Анхдагч хүчин зүйл
c	Капитал	3	Уламжлалт хүчин зүйл

- A. a1,b2,c3                      B. a2,b3,c1                      C. a3,b1,c2                      D. a2,b1,c3

13. Насанд хүрээгүй буюу 14-18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн ямар чадамжтай байх вэ?

- A. Бүрэн чадамжтай                      C. Бүрэн бус чадамжтай  
B. Зарим чадамжтай                      D. Чадамжгүй

14. Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш хэдэн сарын дотор ноогдуулах ёстой вэ?

- A. 1 сар                      B. 3 сар                      C. 5 сар                      D. 6 сар

15. Гэмт хэргийн хохирогчийн эрхээс илүүцийг олно уу.

- A. Давж заалдах гомдол гаргах, тайлбар гаргах  
B. Мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн дуудсанаар ирэх  
C. Мөрдөн байцаалт, прокурор, шүүгчээс татгалзах хүсэлт гаргах  
D. Нотлох баримт гаргах, шалгуулах

16. Дараах ойлголтуудыг зөв тохируулна уу.

a	Хүний эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн баталгаа бий болгох арга хэмжээг авна гэсэн үүргүүд хүлээдэг.	1	Хүндэтгэх
b	Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь сэргээх, хохирлыг арилгах бүтэц, тогтолцоог бий болгох боловсронгуй хууль тогтоомж батлах	2	Хангах
c	Тухайн эрхийг эдлэхэд ямарваа нэгэн саад учруулахгүй, зөрчихгүй байх	3	Хамгаалах

- A. a3,b2,c1                      B. a1,b2,c3                      C. a2,b1,c3                      D. a2,b3,c1

17. Төрийн нэр хүнд, уламжлалт чиг үүрэгт хүндэтгэлтэй ханддаг, нийтийн сайн сайхан, үндэсний уламжлалт үнэт зүйлийг хамгаалах үүднээс төрийн хууль ёсны оролцоо, зохицуулалтыг харьцангуй өндөр түвшинд хадгална гэж үздэг дэглэм аль нь вэ?

- A. Авторитор                      C. Либераль  
B. Консерватив                      D. Охлократ

18. Дараах ойлголтууд аль нь барууны намд хамаарахгүй вэ?

- A. Чөлөөт эдийн засгийг дэмжих                      C. Эдийн засгийн үйл явцыг удирдах  
B. Хувийн бизнесийг дэмжих                      D. Улсын өмчийг хувьчлах

19. Дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

a	Нийгмийн бүлэг, улс төрийн элит, хошуучлагч	1	Анхдагч субъект
b	Хувь хүн	2	Хоёрдогч субъект
c	Улс төрийн байгууллага	3	Дээд түвшний субъект

- A. a3,b1,c2                      B. a3,b2,c1                      C. a2,b3,c1                      D. a2,b1,c3

20. Улс төрийн тухай дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь зөв харгалзуулна уу.

a) Улс төрийн бодлого b) Улс төрийн ухамсар c) Улс төрийн соёл	1	Нийгмийн гишүүдийн дийлэнхийн итгэл үнэмшил, үнэт зүйл бөгөөд тэднээс тухайн улс төрийн систем төр засагт хандах хандлагын илэрхийлэл
	2	Төр, нам, бүлэг, ард түмнийг зохион байгуулах чиглүүлэх хүрээ
	3	Улс төрийн мэдрэмж, ойлголт, уламжлал, үнэлэлт дүгнэлт, үзэл санаа, итгэл үнэмшлийн нийлбэр цогц
	4	Нийгэм дэх улс төрийн харилцаа, засаглалыг хэрэгжүүлэх арга хэлбэр, төр нийгэм хоорондын харилцаа
	5	Улс төрийн эрх мэдэл бүхий байгууллагаас олон түмний түгээмэл эрх ашигт нийцсэн дайчлан гаргах, хуваарилах, зохицуулах, дэмжих чадвар бүхий тасралтгүй үйл явц

- A. a5,b3,c1                      B. a2,b4,c3                      C. a5,b1,c3                      D. a2,b1,c3

- 21.** “Нэгдсэн Үндэсний Байгууллага” хэмээн нэрлэх болсон шалтгаан аль нь вэ?
- A. Олон улсын засгийн газруудын төлөөлөл хуралдаж шийдвэрлэсэн бөгөөд түүний үндсэн дээр НҮБ гэж нэрлэсэн.
  - B. Д. Рузвельтийн дурсгалыг хүндэтгэж, энэ гарамгай зүтгэлтний санал болгосноор НҮБ гэж нэрлэсэн.
  - C. Эдийн засаг, нийгэм, соёл, шинжлэх ухаан-технологийн болон хөгжлийн бусад салбар, хүмүүнлэгийн асуудлаар олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр НҮБ гэж нэрлэсэн.
  - D. Бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудын төлөөлөл хуралдаж шийдвэрлэсэн бөгөөд түүний үндсэн дээр НҮБ гэж нэрлэсэн.
- 22.** Цэгийн оронд тохирох оныг нөхнө үү.  
Зүүн өмнөд Азийн Орнуудын Холбоог ..... Индонез, Тайланд, Сингапур, Малайз, Филиппиний Гадаад хэргийн сайд нарын хурлаар үндэслэн байгуулсан.
- A. 1957 онд                      B. 1967 онд                      C. 1989 онд                      D. 1994 онд
- 23.** Дараах өгөгдлүүдээс олон улсын эрх болон ёс зүйн хариуцлагын зохицуулах үүргийн ангилалд аль нь хамаарах вэ?  
*Өгөгдөл: /1-Зохицуулах; 2-Хамгаалах, 3-Чиглүүлэх; 4-Бэхжүүлэх/*
- A. 1, 2                              B. 1, 3                              C. 2, 3                              D. 2, 4

### САНАМЖ

- Хоёрдугаар хэсгийн даалгаврыг (2.1; 2.2) гүйцэтгэхдээ хариултын хуудас дахь САНАМЖ хэсэгт байгаа зааврын дагуу хариултыг будаарай.

### ХОЁРДУГААР ХЭСЭГ

**2.1** Хүснэгтэд байгаа дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

a) Цагдаагийн байгууллага b) Прокурорын байгууллага c) Шүүх байгууллага d) Өмгөөллийн байгууллага e) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	1	Хууль зүйн зөвлөгөө өгөх өмгөөлөх
	2	Хэргийн шийдвэрлэх гэм буруу хохирлыг эцэлсэн тогтоох
	3	Гэмт буруутай этгээдийн хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирол
	4	Эрүүгийн хэрэгт хяналт тавих ял шийтгэлийг тодорхойлох
	5	Хууль бус үйлдэл хийсэн, бусдад хохирол учруулагч этгээд
	6	Шүүхийн шийдвэрийг биелүүлэх ял эдлүүлэх
	7	Гэмт хэрэг, зөрчил шийтгэлийг тодорхойлох

**2.2** Монгол улсын “Гуравдагч хөрш” орнуудын хамтын үйл ажиллагаа эхэлсэн он болон айлчилсан оныг зөв харгалзуулна уу.

a) 1944 b) 1974 c) 1987 d) 1991 e) 1994	1	Монгол улсад АНУ-ын дэд ерөнхийлөгч Хэнри Уолс өнөөгийн нийслэл Улаанбаатар хотод ..... онд айлчилж байжээ.
	2	Япон Улсын Гадаад хэргийн сайд С.Үно ..... онд Монгол улсад айлчилж байсан.
	3	Япон улс дэлхийн банкттай хамтран ..... онд Монголд хандивлагчдын уулзалтыг Токио хотноо 10 удаа санаачлан зохион байгуулж, техникийн хамтын ажиллагааны тусламж үзүүлж ирсэн.
	4	Турк улсын олон улсын хөгжлийн агентлаг “ТИКА”-гийн шугамаар ..... оноос эхлэн нийт 30 сая ам.долларын техникийн тусламж үзүүлжээ.
	5	Монгол улс болон Япон улсын хоёр талын Парламентын төлөөлөгчид ..... оноос харилцан айлчилжээ.
	6	БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дарга Д.Содном ..... онд Япон улсад айлчилж байсан.
	7	АНУ-ын ерөнхийлөгч Роналд Рэйганы засгийн газрын үед Монгол улстай “Харилцан тохиролцох санамж бичиг”-т гарын үсэг зурж ..... оноос дипломат харилцаа эхэлсэн.